

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
	2.11. Шилэн дансны мэдээлэл	12
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	Менежментийн захидал	14
	3.1 Эргэж төлөгдөх цэвэр зээлийн талаар	14
	3.2 Мөнгөн хөрөнгийн талаар.....	15
	4.1 Дотоод хяналтын талаар.....	15
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	17
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	17
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	19
	4.3 Аудит хийсэн цэвэр мөнгөн гүйлгээний тайлан.....	21
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
	4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24
5	Аудитын хураангуй тайлангийн хавсралт.....	26

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН
САНГИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ М.АРИУНЖАРГАЛ
ТАНАА

2018.03.25 № 06/603
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Боловсролын зээлийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын зээлийн сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Боловсролын зээлийн сангийн санхүүгийн тайланд

- Тайлант онд жилийн эцсийн байдлаар 181,768.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд нийт авлагын 71.2 хувь буюу өмнөх онуудад үүссэн 129,332.4 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогчид тодорхойгүй, авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй,
- Тайлант онд дотоодын их дээд сургуулиудад 29,013.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос 13,661.6 сая төгрөг буюу 47.1 хувийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй,
- Гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдын материалыг түүвэрлэн шалгахад 1,630,177.00 ам.долларын зөрчил илэрсэн. Тухайлбал,
 - Зээлийн албанаас гаргасан мэдээ, тайлан анхан шатны баримтаас 320,131.00 ам.доллороор зөрүүтэй илэрхийлэгдсэн,
 - Нэхэмжлэхгүй, үнийн дүн зөрүүтэй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар суралцагчдад сургалтын төлбөрийг шилжүүлсэн,
 - Тайлант онд үл хөдлөх хөрөнгийг барьцаалахгүйгээр 247,096.00 ам.долларыг сургалтын төлбөрт шилжүүлсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сангийн захирлын үүрэг гүйцэтгэгч М.Ариунжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн мөнгөн хөрөнгө, эргэж төлөгдөх цэвэр зээл, дотоод хяналтын талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 18-наас 2019 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Энхжаргал, гэрээт аудитор М.Алтанхорол нар хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 30 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБООУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Боловсролын зээлийн сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.13, 6 дугаар зүйлийн 6.4.6, 16 дугаар зүйлийн 16.4, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 9.3 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор Сургалтын төрийн санг "Боловсролын зээлийн сан" болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Боловсролын зээлийн сангийн зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Боловсролын зээлийн сан нь дараах үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;
2. Сангийн тухайн жилийн төсвийг боловсруулах;
3. Сургалтын төлбөрийн зээл олгох үйл ажиллагаатай холбогдуулж дээд боловсролын сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулах;
4. Сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах, зээлийн барьцаанд байгаа хөрөнгийн баталгаа бүрдүүлэх;
5. Сургалтын төлбөрийн зээлийн гэрээг зөрчсөн тохиолдолд нэхэмжлэх гаргах;
6. Сургалтын төлбөрийн зээлийг төлөхөөс зайлсхийсэн этгээдэд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
7. Сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэгт хамрагдах суралцагчдын бичиг баримтын бүрдүүлэлт, зээлийг эргэн төлүүлэх асуудлаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах;
8. Сангийн үйл ажиллагааны тайлан гаргах;
9. Сангийн санхүүжилтээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын талаар мэдээллийн сан бүрдүүлэх.

Боловсролын зээлийн сангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Боловсролын зээлийн сангийн удирдлага төсвийн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль
- Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоол

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсролын зээлийн сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журмын өөрчлөлтүүдийг шинэчлэн тусгаагүй байна.

Боловсролын зээлийн сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Боловсролын зээлийн сан санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн "Aculous" програм хангамжийг ашигладаг байна.

Боловсролын зээлийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг үр нөлөөтэй гэж үзлээ.

Боловсролын зээлийн сан нь дотоод аудит, хяналт шинжилгээний 1 мэргэжилтэнтэй бөгөөд 2018 оны 9 дүгээр сараас 2018 оны 12 сарыг дуустал ажлын төлөвлөгөө гарган удирдамжийн дагуу 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажилласан байна. Дотоод хяналт шалгалтаар 961,740.50 ам.доллар, 28.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлсэн гэх ба зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж өгч, ерөнхий нягтлан бодогчтой холбоотой зөрчлүүдийг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Боловсролын зээлийн сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Тус сангийн зарлага 100.0 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан тул зардлын гүйлгээг эрсдэлтэй гэж үзэн материаллаг байдлын суурийг нийт зардлаар сонгов.

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 32,693.0 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 326.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 16 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 12 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд

тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	38,681.3	
2	Албан шаардлага өгсөн	7	155,550.2	
3	Акт тогтоосон	1	111.6	
	Дүн	12	194,343.1	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.8.1.1 Авлага, өглөгийн талаар

- Санхүүгийн тайлангийн аудитаар авлага, өглөгтэй холбоотой нийт 149,263.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:
 - 2018 оны жилийн эцсийн байдлаар 181,768.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд нийт авлагын 71.2 хувь буюу өмнөх онуудад үүссэн 129,332.4 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогчид тодорхойгүй, авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй,
 - Тайлант хугацаанд дотоодын их дээд сургуулиудад 29,013.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос 13,661.6 сая төгрөг буюу 47.1 хувийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй. Үүнд: Оюутны хөгжлийн зээлийн 57.8 хувь буюу 7,605.5 сая төгрөг, буцалтгүй тусламжийн 38.2 хувь буюу 6,056.1 сая төгрөг,
 - Авлагын дэлгэрэнгүй бүртгэл мөнгөн гүйлгээний журналаас 369.6 сая төгрөгөөр, зээлийн албаны гаргасан мэдээ, тайлангаас 1,703.9 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн. Үүнд:
 - Бакалаврын хөтөлбөр: мөнгөн гүйлгээний журналаас 201.9 сая төгрөг, зээлийн албаны мэдээнээс 1,064.0 сая төгрөгөөр,
 - Магистр, докторын хөтөлбөр: мөнгөн гүйлгээний журналаас 93.0 сая төгрөг, зээлийн албаны мэдээнээс 653.6 сая төгрөгөөр,
 - Оюутны хөгжлийн зээл: мөнгөн гүйлгээний журналаас 74.7 сая төгрөг, зээлийн албаны мэдээнээс -13.7 сая төгрөгөөр,
 - Зорилтот хөтөлбөрийн албаны гаргасан мэдээ, тайлан буцалтгүй тусламжийн санхүүжилтийн дүнгээс 2,591.9 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн.

1.5 Тайлант оны жилийн эцсийн байдлаар 674.0 сая төгрөгийн авлага, 929.7 сая төгрөгийн өглөг, нийт 1,603.7 сая төгрөгийн тооцоог хасах дүнгээр бүртгэсэн. Үүнд: Өмнөх онд 547.2 сая төгрөгийн өглөг, тайлант онд 674.0 сая төгрөгийн авлага, 382.5 сая төгрөгийн өглөг,

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "бүх хөрөнгө, ... авлага", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...", 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг үнэн зөв хөтлөх, тайлант хугацаанд гарсан авлага, өглөг, санхүүжилтийн тооцоог нийлж баталгаажуулж байх талаар албан шаардлага хүргүүлэх;

2.8.1.2 Эргэж төлөгдөх цэвэр зээлийн талаар

1. Тайлант хугацаанд гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт хамрагдан санхүүжих 376 суралцагчдын 54.8 хувь буюу 206 суралцагчийн хувийн хэргийг түүвэрлэн шалгахад 1,630,177.00 ам.долларын зөрчил илэрсэн. Үүнд:
 - Дэлхийн шилдэг их дээд сургуулиудын бакалаврын хөтөлбөрт хамрагдагсдын 34.4 хувь буюу 85 суралцагчийг хамруулсан ба 1,213,511.00 ам.долларын зөрчил,
 - Магистр, докторын хөтөлбөрт хамрагдагсдын 93.8 хувь буюу 121 суралцагчийг хамруулсан ба 416,666.00 ам.долларын зөрчил,
 - a. Зээлийн албаны гаргасан мэдээ, тайлан суралцагчдын хувийн хэргээс 320,131.00 ам.доллороор зөрүүтэй илэрхийлэгдсэн. Үүнд: бакалаврын хөтөлбөрт суралцагчдынх 222,076.00 ам.доллороор, магистр, докторын хөтөлбөрт суралцагчдынх 98,055.00 ам.доллороор,
 - b. Нэхэмжлэхгүй, үнийн дүн зөрүүтэй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 42 суралцагчид 1,062,950.00 ам.долларыг шилжүүлсэн. Үүнд: бакалаврын хөтөлбөрийн 22 суралцагчид 879,715.00 ам.долларыг, магистр, докторын хөтөлбөрийн 20 суралцагчид 183,235.00 ам.долларыг,
 - c. Тайлант хугацаанд үл хөдлөх хөрөнгийн барьцааны шаардлага хангахгүйгээр 16 суралцагчдын сургалтын төлбөрт 247,096.00 ам.долларыг олгосон. Үүнд: бакалаврын хөтөлбөрийн 10 суралцагчид 135,376.00 ам.долларыг, магистр, докторын 6 суралцагчид 111,720.00 ам.долларыг,

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах",

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зээл олгох журам"-ын 3.2-т "Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг магистрантад 2 жил, докторантад 3 жил хүртэлх хугацаатайгаар үл хөдлөх хөрөнгө барьцаалан олгоно",

Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ын 2.4-т "сургалтын зээлийг тухайн их сургуулиас ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалан олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаадын их дээд сургуульд суралцагчдын тооцоог үнэн зөв хөтлөх, анхан шатны баримт дутуу баримтаар гүйлгээг хийхгүй байх, сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг олгохдоо холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх;

- 2 Дэлхийн шилдэг их сургуулиудад суралцаж байгаа 5 суралцагчдын сургалтын төлбөрийн санхүүжилтэд 159,098.36 ам.долларын дараах зөрчил илэрсэн. Үүнд:
 - Гантөмөр овогтой Хулан: 2016-2017 онуудад 2 ижил нэхэмжлэхээр 4 удаагийн шилжүүлгээр нийт 151,197.26 ам.долларыг шилжүүлсэн, Үүнд: 1 жилийн сургалтын төлбөр 52,050.50 ам.доллар, бусад төлбөр 23,548.13 ам.доллар байна.
 - Батсуурь овогтой Энхбилгүүн: 2017-2018 оны сургалтын төлбөрт 24,994.00 ам.доллар шилжүүлэхээс 38,534.83 ам.доллар буюу 13,540.83 ам.долларыг илүү шилжүүлсэн,
 - Энхтөр овогтой Цэнгүүн: 2016-2017 оны сургалтын төлбөрт 34,233.00 ам.доллар шилжүүлэхээс 38,840.00 ам.доллар буюу 4,607.00 ам.долларыг илүү шилжүүлсэн, өмнөх оны сургалтын төлбөр 39,497.00 ам.доллар анхан шатны баримтгүй,
 - Батсайхан овогтой Ариунболд: 2018 онд сургалтын төлбөр 11,076.00 ам.доллар шилжүүлэхээс 11,624.08 ам.доллар буюу 548.08 ам.долларыг илүү шилжүүлсэн,
 - Мөнхдаш овогтой Олонбаяр: 2018 онд сургалтын төлбөр болох 16,000.00 ам.долларыг шилжүүлсэн ба сурахгүй гэх шалтгаанаар 14,221.31 ам.доллар буцааж төлөгдсөн. Сургалтын төлбөрийн зөрүү 1,778.69 ам.доллар төлөгдөөгүй байна.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах",

Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг их, дээд сургуульд оюутан суралцуулах журам"-ын 2.3-т "Сургалтын зээл нь сургалтын төлбөр байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн 42,224.04 ам.долларыг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох, анхан шатны баримтгүй шилжүүлсэн, сургалтын төлбөрийн зөрүү 116,874.32 ам.долларын зөрчлийг дахин нягталж арилгуулах талаар албан шаардлага хүргүүлэх,

2.8.1.3 Мөнгөн хөрөнгийн талаар

Тайлант хугацаанд гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа суралцагчдад сургалтын төлбөр болон амьжиргааны зардалд нийт 631,104.51 ам.долларыг хувийн дансанд шилжүүлсэн байна. Үүнд:

- Амьжиргааны зардал 323,612.35 ам.долларыг 33 суралцагчид анхан шатны баримтгүйгээр,
- Сургалтын төлбөр 307,492.16 ам.долларыг 22 суралцагчид. Үүнд: бакалаврын хөтөлбөрт суралцагчдад 127,662.50 ам.доллар, магистр, докторын хөтөлбөрт суралцагсдад 179,829.66 ам.доллар

Эдгээр зөрчил нь Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 4.4.6-д "... дээд боловсролын сургалтын байгууллагад суралцуулах урилга, сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын нэхэмжлэл, харилцах данс", 5.4-д "Сургалтын төлбөрийн зээлийн санхүүжилтийг тухайн суралцагчийн суралцаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын дансанд шилжүүлнэ", Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ын 2.6-д "Сургалтын төлбөрийг суралцагчийн суралцаж буй их сургуулийн дансанд шилжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид суралцагчдын сургалтын төлбөрийг суралцаж буй сургуулийн дансанд шилжүүлж байх, амьжиргааны зардлыг анхан шатны баримтыг үндэслэн холбогдох журмын дагуу шилжүүлж байх талаар албан шаардлага хүргүүлэх,

2.8.1.4 Санхүүгийн тайлагналын талаар

Тайлант оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл 2017 оны санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 424.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Үүнд: Санхүүгийн байдлын тайлан 268.3 сая төгрөгөөр, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 156.3 сая төгрөгөөр,

Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийн татаас санхүүжилтийн авлагыг болон байгууллагад төлөх өглөгийг 382.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, зээлийн авлагыг 205.2 сая төгрөгөөр бууруулан бүртгэсэн боловч тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй байна.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ",

АОУС 510 "Эхний аудитын гэрээт ажил – эхний үлдэгдэл" 46 "... Эхний үлдэгдэл нь өмнөх үеийн эцсийн үлдэгдэл дээр тулгуурлах бөгөөд мөн өнөөх үеүдийн ажил гүйлгээ, үйл явдлуудын үр нөлөөг болон өмнөх үед ашигласан бодлогуудыг тусгана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг аудитын явцад залруулсан.

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Боловсролын зээлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар оюутны хөгжлийн зээл болон зээлийн хүүгийн тооцоолол, буцалтгүй тусламжийн зардал, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж байгаа зардалтай холбоотой асуудлыг мөшгин шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх.

Мөн Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр Дэлхийн шилдэг сургуульд суралцахаар шалгарсан суралцагсдыг холбогдох баримтгүйгээр өөр суралцагчдаар сольж суралцуулсан, суралцагсдын сургуулийг сольсон, Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын бакалаврын хөтөлбөрт хамрагдсан суралцагчид магистрын хөтөлбөр болон засгийн газрын тэтгэлэгт давхар хамрагдсан болон суралцагчдын үл хөдлөх хөрөнгийн барьцааны үнэлгээ, лавлагааны талаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын хувийн хэрэг, дотоодын их дээд сургууль төгсөгчдийн дипломын хадгалалт хамгаалалт, бүртгэл хөтөлөлтийг сайжруулах талаар анхааран ажиллах шаардлагатай байна.

2.10. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Боловсролын зээлийн сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 хөтөлбөр, 12 арга хэмжээнд зориулан тайлант онд 118,901.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт зарлага ба цэвэр зээл 51,801.0 сая төгрөг буюу 43.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Бүлгийн дүнгээр зардлыг хэтрүүлэн зарцуулаагүй байна. Нийт зарлага ба цэвэр зээл дутуу зарцуулалттай байгаа нь эргэж төлөгдөх цэвэр зээл 33.6 хувь буюу 32,476.9 сая төгрөгийн, урсгал шилжүүлэг 87.1 хувь буюу 19,006.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын 99.7 хувь буюу 51,645.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 0.3 хувь буюу 52.0 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Боловсролын зээлийн сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Боловсролын зээлийн сан нь шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу байршуулан ажиллаж байна.

Тус сан нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар бэлтгээгүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнээгүй, албан шаардлага зөвлөмжүүд хэрэгжээгүй байна.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 150,211.3 сая төгрөгийн авлагыг баталгаажуулах, эргэн төлөгдөх зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй суралцагчдын гэрээний үүргийг хангуулах, буцалтгүй тусламжийн өндөр онооны тэтгэлгийн зохицуулалтыг тодорхой болгох, суралцагчдын зээлийн чөлөөлөлтийг холбогдох хууль, тогтоомжтой нийцүүлэх, магистр, докторын хөтөлбөрт хамрагдагсдын сургалтын төлбөр, амьжиргааны зардлын хэмжээг тодорхой болгож эрх зүйн актаар баталгаажуулах талаар албан шаардлага зөвлөмжийг өгсөн болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсролын зээлийн сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Боловсролын зээлийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ТАЛААР

3.1.1 Илрүүлэлт:

Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаад төгсөж ирсэн 263 төгсөгчид гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй байна. Үүнд:

1. Магистр, докторын хөтөлбөрт хамрагдан 4,506,700.00 ам.долларын санхүүжилт авсан 179 суралцагч,
2. Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт хамрагдан 10,114,446.00 ам.долларын санхүүжилт авсан 84 суралцагч,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ",

Боловсрол, Шинжлэх ухаан, Спортын сайд, Сангийн сайдын хамтран баталсан 2014 оны "Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ"-ний 3.6-д "Их сургуулиа төгсөж эх орондоо ирснээс хойш ажлын 21 хоногийн дотор Сургалтын төрийн санд өөрийн биеэр ирж мэдэгдэнэ", 3.9-д "Суралцагч гэрээгээ зөрчсөн тохиолдолд зээлийг Сургалтын төрийн санд буцааж төлнө",

Гадаад орны дээд боловсролын байгууллагад суралцагчдад зээл олгох эргэн төлүүлэх тухай гэрээний 3.5-д "Их сургуулиа төгсөж ирсэн даруйдаа энэ тухай сургалтын төрийн санд ирж мэдэгдэнэ",

... Үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний 4.1-д "Зээлдэгч зээлийн гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй бол энэ гэрээнд заасан журмаар захиран зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Сургалтын зээл төлөгдөхгүй байх, найдваргүй авлага үүсэх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, тогтоомжийн дагуу суралцагчдын гэрээний үүргийг хангуулж ажиллах,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

3.2 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 27.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Үүнд: Монгол банкин дахь дансны үлдэгдэл 0.6 сая, Сангийн яаманд Сургалтын төрийн сан нэрээр нээгдсэн орлогын данс 26.9 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "бүх хөрөнгө, ... авлага", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...", 20.2.6-д "... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, авлага зөрүүтэй илэрхийлэгдэх,

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Тайлан бэлтгэхийн өмнө дансны үлдэгдлийг тулган баталгаажуулж, санхүүгийн тайланг бэлтгэх,

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

4.1 ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР

4.1.1 Илрүүлэлт:

Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагсдын бүртгэлийг хөтлөх програмтай боловч тайлант онд програмыг хөтлөөгүй, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 6.1-д "Сургалтын төрийн сан нь сургалтын төлбөрийн болон амьжиргааны

зардлын зээл авсан суралцагчдын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлж ажиллана", Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ын 1.8-д "Сургалтын төрийн сан нь сургалтын зээлээр суралцагчид болон тэдний суралцаж буй их сургуультай харилцан мэдээлэл солилцож, мэдээллийн сан бүрдүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад олгох зээл давхардах, мэдээллийн найдвартай байдал алдагдах,

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Суралцагчдын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж ажиллах,

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

4.2.1 Илрүүлэлт:

Дотоод аудит болон санхүүгийн ажилтан нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бэлтгээгүй, дүгнээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ын 6.1.6-д "өмнө хийсэн ... санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл: Зөрчил давтагдан гарах,

4.2.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах,

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	157,421,668,859.53	185,000,889,652.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	103,631,169.61	561,947,727.23
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	103,631,169.61	561,947,727.23
31210	Төгрөг	103,631,169.61	616,600.54
31211	Төрийн сангийн харилцах	103,631,169.61	561,331,126.69
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	616,600.54
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	7,099,995,789.96	1,416,114,765.36
321	Үнэт цаас	7,099,995,789.96	1,416,114,765.36
32110	Төгрөг	7,099,995,789.96	1,416,114,765.36
33	АВЛАГА	150,211,329,299.06	183,019,137,260.26
33300	Татаас санхүүжилтийн авлага		1,250,393,673.14
33400	Зээлийн хүүгийн авлага	2,553,306.10	2,330,054.58
33500	Бусад авлага	150,208,775,993.86	168,618,212,977.34
33510	Байгууллагаас авах авлага	150,208,775,993.86	168,618,212,977.34
336	Зээлийн авлага	150,208,775,993.86	13,148,200,555.20
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	150,208,775,993.86	13,148,200,555.20
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	150,208,775,993.86	13,148,200,555.20
34	УРЬДЧИЛГАА	5,123,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	5,123,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,589,600.00	3,689,900.00
35400	Хангамжийн материал	1,589,600.00	3,689,900.00
35410	Бичиг хэргийн материал	1,589,600.00	3,689,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	137,432,531.62	173,209,029.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	137,432,531.62	173,209,029.54
39200	Биет хөрөнгө	67,172,918.28	50,191,436.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,800,000.00	49,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,914,575.46	-43,214,575.50
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	99,014,361.50	99,014,361.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-73,557,553.33	-77,576,277.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,357,295.86	51,357,295.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,526,610.29	-29,189,368.29
39300	Биет бус хөрөнгө	70,259,613.34	123,017,593.34
39301	Програм хангамж	140,320,200.00	140,320,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-70,060,586.66	-17,302,606.66
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	157,559,101,391.15	185,174,098,682.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,148.00	8,982,928.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,148.00	8,982,928.01
41300	Өглөг	32,148.00	8,982,928.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	32,148.00	-
41360	Бусад өглөг	-	8,982,928.01
41361	Байгууллагад төлөх өглөг	-	8,982,928.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	157,559,069,243.15	185,165,115,754.38
51	Засгийн газрын хувь оролцоо	157,559,069,243.15	185,165,115,754.38
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	29,809,531.00	29,809,531.00

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: төрийн	29,809,531.00	29,809,531.00
51200	Хуримтлагдсан үр дүн	157,529,259,712.15	185,135,306,223.38
51210	Өмнөх үеийн үр дүн	135,197,124,124.23	157,182,420,675.29
51220	Тайлант үеийн үр дүн	22,332,135,587.92	27,952,885,548.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	157,559,101,391.15	185,174,098,682.39

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	47,336,570,289.96	59,211,246,071.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,154,993,073.53	534,200,225.91
120	Нийтлэг татварын бус орлого	1,154,993,073.53	534,200,225.91
120002	Хүүгийн орлого	158,833,124.35	67,549,381.23
120009	Бусад орлого	996,159,949.18	466,650,844.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,181,577,216.43	58,677,045,846.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	46,122,643,721.11	58,676,780,846.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	46,122,643,721.11	58,676,780,846.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,547,816.32	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,547,816.32	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,385,679.00	265,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,385,679.00	265,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	24,916,394,460.11	31,442,642,431.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,916,394,460.11	31,442,642,431.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	360,725,685.33	383,173,081.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,315,732.98	224,147,475.00
210101	Үндсэн цалин	248,315,732.98	224,147,475.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,713,817.00	27,376,631.20
210201	Тэтгэврийн даатгал	17,950,467.00	18,342,288.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,171,829.00	2,113,976.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,236,198.00	1,976,557.40
210204	Ажилгүйдлийн даатгал	486,848.00	449,435.72
210205	Эрүүл мэндийн даатгал	4,868,475.00	4,494,373.20
2104	Хангамж, бараа материалын зардал	11,346,286.11	25,626,624.30
210401	Бичиг хэрэг	1,984,600.00	7,196,660.00
210402	Тээвэр, шатахуун	1,366,000.00	6,009,876.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,734,751.57	7,889,762.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,260,934.54	4,530,325.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,723,000.00	5,500,000.00
210604	Урсгал засвар	1,723,000.00	5,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	470,100.00	1,304,000.00
210702	Дотоод албан томилолт	470,100.00	1,304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,357,704.00	14,933,704.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,226,004.00	7,480,204.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,131,700.00	7,453,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,799,045.24	84,284,646.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,230,000.00	15,538,603.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	13,441,392.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,569,045.24	55,304,650.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,555,668,774.78	31,059,469,349.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,973,388,995.74	18,886,469,289.55
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	275,966,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,690,822,995.74	18,886,469,289.55
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,582,279,779.04	12,173,000,060.36

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,582,279,779.04	12,173,000,060.36
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	22,420,175,829.85	27,768,603,640.53
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	147,679,208.25	227,480,151.92
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	147,679,208.25	227,480,151.92
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	235,719,450.17	43,198,244.36
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	82,773,200.73	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	152,946,249.44	43,198,244.36
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	22,332,135,587.92	27,952,885,548.09

4.3 Аудит хийсэн цэвэр мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	48,348,719,742.76	65,275,750,756.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	610,761,299.43	6,598,969,910.19
120	Нийтлэг татварын бус орлого	610,761,299.43	4,085,222,862.00
120002	Хүүгийн орлого	156,279,818.25	67,772,632.75
120009	Бусад орлого	454,481,481.18	4,017,450,229.25
124	Зээлийн орлого	1,608,885,523.22	2,513,747,048.19
141001	Зээлийн эргэн төлөлт	1,608,885,523.22	2,513,747,048.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	47,737,958,443.33	58,676,780,846.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	47,731,529,244.33	58,676,780,846.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	46,122,643,721.11	58,676,780,846.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	1,608,885,523.22	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,429,199.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,429,199.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,460,580,159.80	32,598,209,613.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,460,580,159.80	32,598,209,613.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320,878,777.55	320,670,676.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,327,102.43	224,639,116.57
210101	Үндсэн цалин	225,803,302.43	155,625,073.19
210102	Нэмэгдэл	13,180,200.00	43,180,443.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,343,600.00	25,833,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,713,819.56	26,721,096.10
210201	Тэтгэврийн даатгал	27,713,819.56	24,468,996.10
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,252,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,057,051.57	18,592,762.86
210401	Бичиг хэрэг	7,104,300.00	5,706,960.00
210402	Тээвэр, шатахуун	6,222,200.00	1,998,715.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,267,751.57	6,356,762.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	462,800.00	4,530,325.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,723,000.00	5,500,000.00
210604	Урсгал засвар	1,723,000.00	5,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	470,100.00	1,304,000.00
210702	Дотоод албан томилолт	470,100.00	1,304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,357,704.00	14,933,704.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,226,004.00	7,480,204.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,131,700.00	7,453,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,230,000.00	28,979,996.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,230,000.00	15,538,603.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	13,441,392.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,139,701,382.25	32,277,538,937.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,973,388,995.74	18,854,145,203.54
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	275,966,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,690,822,995.74	18,854,145,203.54
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,166,312,386.51	13,423,393,733.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,166,312,386.51	13,423,393,733.50

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,888,139,582.95	32,677,541,143.12
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	109,372,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	109,372,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	109,372,900.00	-
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	109,372,900.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-109,372,900.00	-
14	Бусад эх үүсвэр	-	227,480,151.92
145001	Гадаад валютын ханшийн олз	-	227,480,151.92
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЗЭЭЛ	22,704,155,197.54	32,403,506,493.05
230001	Эргэж төлөгдөх зээл	22,704,155,197.54	32,403,506,493.05
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	10,763,005.20	43,198,244.36
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	10,763,005.20	43,198,244.36
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	22,888,139,582.96	-32,219,224,585.50
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	63,848,480.21	458,316,557.62
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,782,689.40	103,631,169.61
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	103,631,169.61	561,947,727.23

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	29,809,531.00	-	138,739,083,237.23	138,768,892,768.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-3,541,959,113.00	-3,541,959,113.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	-	135,197,124,124.23	135,226,933,655.23
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн	-	-	22,332,135,587.92	22,332,135,587.92
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	-	157,529,259,712.15	157,559,069,243.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	346,839,036.86	346,839,036.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	-	157,182,420,675.29	157,212,230,206.29
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн	-	-	27,952,885,548.09	27,952,885,548.09
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	-	185,135,306,223.38	185,165,115,754.38

4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Тайлант оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,901,503,900.00	51,801,015,874.58	67,100,488,025.42	43.6
УРСГАЛ ЗАРДАЛ	22,101,503,900.00	19,324,075,513.30	2,777,428,386.70	87.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	293,865,600.00	291,690,679.53	2,174,920.47	99.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,205,200.00	224,639,116.57	566,083.43	99.7
Үндсэн цалин	155,928,100.00	155,625,073.19	303,026.81	99.8
Нэмэгдэл	43,443,500.00	43,180,443.38	263,056.62	99.4
Унаа хоолны хөнгөлөлт	25,833,600.00	25,833,600.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,024,700.00	26,721,096.10	303,603.90	98.9
Тэтгэврийн даатгал	27,024,700.00	24,468,996.10	2,555,703.90	90.5
Тэтгэмжийн даатгал	-	2,252,100.00	-2,252,100.00	-
Хангамж, бараа материалын зардал	19,845,900.00	18,592,762.86	1,253,137.14	93.6
Бичиг хэрэг	6,384,000.00	5,706,960.00	677,040.00	89.4
Тээвэр, шатахуун	2,888,500.00	1,998,715.00	889,785.00	69.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,619,900.00	6,356,762.86	1,263,137.14	83.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,953,500.00	4,530,325.00	1,576,825.00	153.4
Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	5,500,000.00	-	100.0
Урсгал засвар	5,500,000.00	5,500,000.00	-	100.0
Томилолт, зочны зардал	1,336,300.00	1,304,000.00	32,300.00	97.6
Дотоод албан томилолт	1,336,300.00	1,304,000.00	32,300.00	97.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,953,500.00	14,933,704.00	19,796.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,500,000.00	7,480,204.00	19,796.00	99.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,453,500.00	7,453,500.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,807,638,300.00	19,006,327,822.03	2,801,310,477.98	87.1
Бусад урсгал шилжүүлэг	21,807,638,300.00	19,006,327,822.02	2,801,310,477.98	87.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	147,392,000.00	-	147,392,000.00	-
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	21,660,246,300.00	19,006,327,822.02	2,653,918,477.98	87.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	26,057,011.74	-26,057,011.74	-
Гадаад эх үүсвэрээр	-	26,057,011.74	-26,057,011.74	-
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	96,800,000,000.00	32,476,940,361.28	64,323,059,638.72	33.6
Эргэж төлөгдөх зээл	96,800,000,000.00	32,476,940,361.28	64,323,059,638.72	33.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	118,901,503,900.00	51,697,384,704.97	67,204,119,195.03	43.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	118,901,503,900.00	51,645,381,323.25	67,256,122,576.75	43.4

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улсын төсвөөс санхүүжих	118,901,503,900.00	51,645,381,323.25	67,256,122,576.75	43,4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	52,003,381.72	-52,003,381.72	
Ханшийн орлого	-	52,003,381.72	-52,003,381.72	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	103,631,169.61	-103,631,169.61	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	561,331,126.69	-561,331,126.69	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	-	100.0
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	-	100.0

5 АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/17/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Боловсролын зээлийн сан			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Сургалтын төлбөрийг илүү шилжүүлсэн	111.8	Акт	Захирал Ерөнхий нягтлан бодогч	П.Лхагвасүрэн А.Өнөрцэцэг
2	Авлагын дэлгэрэнгүй бүртгэл бүрэн хөтлөөгүй, авлагын дэлгэрэнгүй бүртгэл, мөнгөн гүйлгээний журналаас зөрүүтэй илэрхийлэгдсэн, авлага өглөгийг зөрүүтэй бүртгэсэн	149,263.1	Албан шаардлага	Захирал, Захирлын үүрэг гүйцэтгэгч Ерөнхий нягтлан бодогч	П.Лхагвасүрэн, М.Ариунжаргал А.Өнөрцэцэг
3	Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, тайлан зөрүүтэй илэрхийлэгдсэн	4,618.7	Албан шаардлага	Захирал, Захирлын үүрэг гүйцэтгэгч Ерөнхий нягтлан бодогч	П.Лхагвасүрэн, М.Ариунжаргал А.Өнөрцэцэг
4	Суралцагчдын төлбөрийг хувийн дансанд шилжүүлсэн	1,668.4	Албан шаардлага	Захирал, Захирлын үүрэг гүйцэтгэгч Ерөнхий нягтлан бодогч	П.Лхагвасүрэн, М.Ариунжаргал А.Өнөрцэцэг
5	Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн бэлтгээгүй	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Б.Булганзаяа
6	Гадаадын дээд боловсролын байгууллагад суралцаад төгсөж ирсэн суралцагчид гэрээний үүргээ биелүүлээгүй	38,653.8	Зөвлөмж	Гадаад зээлийн мэргэжилтэн	К.Шолпан П.Отгонжргал
7	Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн	27.5	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	А.Өнөрцэцэг
8	Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагсдын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлээгүй	-	Зөвлөмж	Захиргаа, хүний нөөц, хамтын ажиллагаа, ажлын албаны дарга	Б.Отгонтөгс

Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	Өмнө өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаагүй, дүгнээгүй	-	Зөвлөмж	Дотоод аудит, хяналт шинжилгээний мэргэжилтэн, Ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодогч	Ц.Болормаа А.Өнөрцэцэг Б.Булганзаяа
	Нийт дүн	194,343.3			